

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/19

Даланзадгад сум

┌ Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай ┐
зөвшөөрлийг шинээр олгох,
хугацааг сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.12 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцэн, тусгай зөвшөөрлийг шинээр олгосон, хугацааг сунгасан, эмийн сангийн байршил солих хүсэлтийг шийдвэрлэсэн эмийн сангийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, хугацааг сунгасан эмийн сангийн тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн улсын ахлах байцаагч (У.Дөшбат) нарт тус тус даалгасугай.

3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

• 462501136

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 дүгээр сарын 11-ны өдрийн
А/119 дугаар тушаалын хавсралт

Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан,
хаяг байршил сольсон, шинээр олгосон эмийн сангийн нэрс

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1	Жанжинговь ОНӨААТҮГ Жанжинговь эмийн эргэлтийн сан ЭЭС-06/14/42	3611949	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2030 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүртэл	Хүрмэн сум, Хүрмэн 3-р баг, Аргалант 1 тоот
Эмийн сангийн байршил сольсон					
2	Арвайн шимт хур ХХК Итгэл эмийн сан ЭСХ- 19/14/102	3635848	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр хүртэл	Даланзадгад сум, Гурван сайхны 8-р гудамж, 836 тоот
3	Манхүг ХХК Манхүг эмийн сан ЭСХ- 17/14/87	3628329	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2028 оны 03 дугаар сарын 29-ний өдөр хүртэл	Даланзадгад сум, 6-р баг, Gobi Residence байрны 103, 104 тоот
Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон					
4	Уужим сутай гурван билигт ХХК Уужим сутай фарм эмийн сан	3661938	Хүний эм эмнэлгийн хэрэгсэл худалдах	2028 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл	Цогт-Овоо сум, Замын шанд баг, Худалдааны гудамж 1-2 тоот